



**ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 60

Чингис хот


**Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 130 дугаар тогтоолоор туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Ганбат овогтой Анхбатыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын Хэрлэн сумын Байгаль хамгаалагчийн сул ажлын байранд санал болгосугай.

2. Энэхүү тогтоолыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/-д хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР